

Компанийн засаглалын үйл ажиллагааны тайлан – Монголын цахилгаан холбоо ХК			
<p>"Компанийн засаглалын кодекс"-ийн зарчмын зүйл тус бүрээр үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайланг дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэнэ.</p> <p>Кодексийн хэрэгжилтийг олон улсад түгээмэл тогтсон "Хэрэгжүүл, эсвэл тайлбарла" гэсэн зарчмын дагуу тайлагнахдаа кодекст дурдсан зарчмын зүйл тус бүрээр биелүүлсэн эсэх, биелүүлээгүй бол яагаад биелүүлээгүй, түүнийг орлох бүтэц, зохион байгуулалтын ямар арга хэмжээ авсныг тайлбар хэсэгт нарийвчлан тайлбарлана.</p>			
<p>НЭГДҮГЭЭР ЗАРЧИМ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ</p> <p>Төлөөлөн удирдах зөвлөл нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэц байна.</p>			
	Хэрэгжилт	Тайлбар	
1	<p>1.1. Компани нь төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмаар төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулна.</p>	<p>Биелүүлсэн</p> <p>ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар гишүүд, ТУЗ-ийн дарга, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулсан. ТУЗ-ийн нарийн бичгийн даргын үйл ажиллагааны журмыг мөрдөн ажилладаг. 2024 оны 9 сард уг журамд нэмэлт орууллаа.</p> <p>ТУЗ-ийн үйл ажиллагааны журам ҮЗЭХ</p>	<p>ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд гишүүд ямар тохиолдолд хөндлөнгийн мэргэжлийн этгээдийн зөвлөгөөг компанийн зардлаар авч болох талаарх зохицуулалтыг тусган нэмэлт оруулсан.</p>
2	<p>1.2. Компани нь төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг тусгасан нэр дэвшүүлэх журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна.</p>	<p>Биелүүлсэн</p> <p>Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг Компанийн тухай хуулийн хүрээнд, ТУЗ-өөс томилсон ажлын хэсэг зохион байгуулдаг. ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд тухайлсан зохицуулалтууд байдаг. Мөн Нэр дэвшүүлэх хорооны журмаар зохицуулдаг.</p> <p>Нэр дэвшүүлэх хорооны журам (ҮЗЭХ), Залгамж халааны бодлогын баримт бичиг (ҮЗЭХ)-ийг 2023 оны эхний хагас жилд баталж, 2023 оны 11 сард дахин шинэчлэн баталсан.</p>	

3	<p>1.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн бүрийн ажлын туршлага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшлийн хувь хэмжээ, хуралдаанд оролцсон ирц зэрэг мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайланд дэлгэрэнгүйгээр тусгаж, өөрийн цахим хуудсанд байршуулна.</p>	<p>Бүрэн хэрэгжүүлж ажилладаг.</p> <p>ТУЗ-ийн жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, жилийн эцэст үйл ажиллагааны тайланг хэлэлцдэг. ТУЗ-ийн гишүүнд хуралдаанд оролцсон ирцтэй уялдуулж, цалин урамшууллыг олгох зарчим баримтлан ажилладаг. Төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэн ажилладаг 6 ТУЗ-ийн гишүүнтэй бөгөөд хараат бус гишүүдийг нээлттэй сонгон шалгаруулж, нэр дэвшүүлэх хорооноос хувьцаа эзэмшигчдийн хуралд шууд нэр дэвшүүлдэг. ТУЗ жилийн үйл ажиллагаа, гишүүдийн ирц, зардлын гүйцэтгэлийнхээ талаар хэлэлцэн дүгнэсэн. ТУЗ үйл ажиллагааны тайлангаа 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар танилцуулж, хувьцаа эзэмшигчдэд тайлагнасан.</p> <p>ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланг хавсаргав. Үйл ажиллагааны тайланг ҮЗЭХ</p>	<p>ТУЗ болон түүний дэргэдэх хороод, ТУЗ-ийн дарга, гишүүдийн жилийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх үнэлгээний загварыг боловсруулан, тайлагналыг шинэчлэхээр ажиллаж байна. 2024 оны жилийн эцсээр үнэлгээг хүргүүлнэ.</p>
4	<p>1.4. Компани нь төлөөлөн удирдах зөвлөлийн болон түүний дэргэдэх хороодын бүтэц, бүрэлдэхүүний бодлогын баримт бичигтэй байх ба уг баримт бичигт гишүүний боловсрол, мэргэшил, ур чадвар, туршлагад тавигдах шаардлага болон хүйсийн тэнцвэр зэрэг асуудлыг тусгана.</p>	<p>Хэрэгжүүлэн ажиллаж байна</p> <p>ТУЗ болон дэргэдэх хороодын журмыг боловсруулж баталсан. Журмуудыг компанийн вэб сайтад нээлттэй байршуулсан болно.</p> <p>Компанийн эрх зүйн актууд ҮЗЭХ</p>	
5	<p>1.5. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг анх томилогдоход чиглүүлэх сургалтыг зохион байгуулах ба ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэг, мэдээллийг олгох, шинэчлэх сургалтад тогтмол хамруулна.</p>	<p>Биелүүлсэн</p> <p>ТУЗ-ийн гишүүнийг анх томилогдоход компанийн дүрэм, стратеги, бизнес төлөвлөгөө, холбогдох журам зэргийг танилцуулдаг. ТУЗ-ийн гишүүдийн жилийн чиглүүлэх сургалтын төлөвлөгөөг батлан мөрдөж ажилладаг. Гишүүдийг компанийн засаглал ахисан түвшний болон бусад сургалтад хамруулдаг.</p> <p>ТУЗ-ийн гишүүдэд зориулсан 2024 оны жилийн сургалтын хөтөлбөрийг хавсаргав.</p>	<p>ТУЗ-ийн бүрэлдэхүүнд зориулсан 2024 оны жилийн сургалтын хөтөлбөрийг ТУЗ-ийн хурлаараа хэлэлцэн шинэчлэн баталсан. Жилийн сургалтын хөтөлбөр нь дараа оны ХЭХ хүртэл хугацаанд хэрэгжинэ.</p>

6	1.6. Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг зохистой явуулах асуудлаар төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар дамжуулан хариуцлага хүлээнэ.	<p style="text-align: center;">Биелүүлсэн</p> <p>Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын үйл ажиллагааны талаар ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын Зургаа дугаар бүлэгт заасан. Мөн ТУЗ-ийн Нарийн бичгийн даргын үйл ажиллагаагын журам (ҮЗЭХ)-ыг шинээр батласан бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга нь ТУЗ-ийн НБД-ын үйл ажиллагааг хянах, дүгнэх асуудлыг тусгасан байна.</p>	Тайланг тайлант хугацаагаар гарган хүргүүлнэ.
<p style="text-align: center;">ХОЁРДУГААР ЗАРЧИМ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ</p> <p>Төлөөлөн удирдах зөвлөл нь өөрийн үйл ажиллагааг тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн хариуцлагыг хүлээнэ</p>			
7	2.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга болоод төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байхыг зорино.	<p style="text-align: center;">Биелүүлсэн</p> <p>ТУЗ нь бүрэлдэхүүн 9 гишүүнтэй бөгөөд 3 гишүүн нь хараат бус гишүүн байдаг. Цаашид олон нийтийн хяналтыг сайжруулах зорилгоор жижиг хувьцаа эзэмшигчдийн төлөөллийг хэрэгжүүлэх хараат бус гишүүнтэй болох талаар зорин ажиллаж ТУЗ-ийн нэр дэвшүүлэх хорооны журамд.</p> <p>Нэр дэвшүүлэх хорооны журам (ҮЗЭХ)</p>	Нэр дэвшүүлэх хорооны журамд ТУЗ-ийн дарга болон гишүүдийн олонхыг хараат бус болгох зорилтыг тусган 2024 оны 9 сард нэмэлт өөрчлөлт оруулсан.
8	2.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хороо нь үйл ажиллагааны журам аудитын бодлогын баримт бичигтэй байна. Аудитын хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бус байна. Аудитын хорооны хуралд компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд гагцхүү тус хорооны хүсэлтээр оролцоно.	<p style="text-align: center;">Биелүүлсэн</p> <p>Аудитын хорооны дарга нь хараат бус гишүүн байдаг ба, аудитын хороо шаардлагатай тохиолдолд (Бизнес төлөвлөгөөний төсөл гэх мэт) компанийн холбогдох захирал, мэргэжилтнүүдийг оролцуулан хуралддаг. Бусад тохиолдолд тусдаа хуралдаж шийдвэр гаргадаг.</p> <p>2023 онд Аудитын хорооны журам (ҮЗЭХ), Дотоод хяналтын бодлогын баримт бичиг (ҮЗЭХ), Дотоод аудитын журам (ҮЗЭХ) зэрэг журмыг батлан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p>	

9	<p>2.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх цалин урамшууллын хороо нь цалин, урамшууллын үйл ажиллагааны журам, цалин урамшууллын бодлогын баримт бичигтэй байна. Цалин урамшууллын хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна. Цалин урамшууллын хорооны хуралд гүйцэтгэх удирдлага гагцхүү хорооны хүсэлтээр оролцоно.</p>	<p style="text-align: center;">Биелүүлсэн</p> <p>ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшууллын хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бус, мөн хараат бус гишүүн байдаг. Гүйцэтгэх захирлын цалин урамшуулал, компанийн цалингийн бодлогын талаар хяналт тавин ажилладаг.</p> <p>2023 онд Цалин урамшууллын хорооны ажиллах журмыг (ҮЗЭХ) боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллаа.</p>	
10	<p>2.4. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо нь үйл ажиллагааны журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна. Нэр дэвшүүлэх хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна.</p>	<p style="text-align: center;">Биелүүлсэн</p> <p>Нэр дэвшүүлэх хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, хараат бус гишүүн байдаг. ТУЗ-ийн нэр дэвшүүлэх хорооны журам (ҮЗЭХ), Залгамж халааны бодлогын баримт бичиг (ҮЗЭХ) шинэчлэн баталсан.</p> <p>ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан тогтоолыг хавсаргав.</p>	<p>ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан бөгөөд Нэр дэвшүүлэх хорооны даргаар хараат бус гишүүн С.Цолмонг томилсон.</p>
11	<p>2.5. Төлөөлөн удирдах зөвлөл нь өөрийн дэргэд бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог байгуулж болно. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод бүгд үйл ажиллагааны журам, заавартай, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, ажлын туршлага бүхий бүрэлдэхүүнтэй байна.</p>	<p style="text-align: center;">Биелүүлсэн</p> <p>Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод нь чиг үүргээ хэрэгжүүлэх шаардлагатай мэдлэг, ур чадвар, ажлын туршлага бүхий бүрэлдэхүүнтэй байдаг.</p> <p>Төлөөлөн удирдах зөвлөлд нэр дэвшүүлэх, хараат бус сонгон шалгаруулалт зохион байгуулахад ТУЗ нь түр хороо буюу ажлын хэсгийг тухай бүр байгуулан ажилладаг.</p>	
ГУРАВДУГААР ЗАРЧИМ. ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ			
<p>Төлөөлөн удирдах зөвлөл нь санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал, мэдээллийн ил тод байдлын үнэн, бүрэн, тэнцвэрт байдлыг хангана</p>			
12	<p>3.1. Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмыг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.</p>	<p style="text-align: center;">Биелүүлсэн</p> <p>ТУЗ нь мэдээллийн ил тод байдал, тайлагналын журам (ҮЗЭХ)-ыг батлан мөрдүүлж, ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар дамжуулан тайлагнаж, хяналт тавин ажиллаж байна.</p>	

13	3.2. Төлөөлөн удирдах зөвлөл нь энэхүү кодекст заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэнэ.	<p style="text-align: center;">Биелүүлсэн</p> <p>Энэхүү кодекст заасан болон бусад компанийн мөрдөгдөж буй дүрэм, журмыг компанийн вэбсайтад байршуулсан.</p> <p>https://telecommongolia.mn/company/rules</p>	
14	3.3. Санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал нь тэнцвэртэй, тодорхой, бодит байна. Санхүүгийн бус тайлан нь хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд компанийн тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс, эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилго, зорилтууддаа хүрсэн эсэхийг үнэлсэн мэдээлэл байна.	<p style="text-align: center;">Биелүүлсэн</p> <p>Санхүүгийн хагас жил, жилийн эцсийн тайлан, аудитлагдсан тайлан, компанийн тайлан болон ТУЗ-ийн тайлангуудыг компанийн вэбсайтад тухай бүр байршуулсан байдаг.</p> <p>Санхүүгийн бус тайлагнал буюу үйл ажиллагааны тайланг мөн тухай бүр ил тод нээлттэй байршуулдаг.</p> <p>https://telecommongolia.mn/company/construct</p>	
<p>ДӨРӨВДҮГЭЭР ЗАРЧИМ. АУДИТ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО</p> <p>Төлөөлөн удирдах зөвлөл нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангана.</p>			
15	4.1. Төлөөлөн удирдах зөвлөл нь аудитын хорооны үйл ажиллагааны журамд хөндлөнгийн аудитортай харьцах, хөндлөнгийн аудиторыг хуульд заасан чиг үүргээ саадгүй гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах талаар тусгаж, журмын хэрэгжилтэд хяналт тавина.	<p style="text-align: center;">Биелүүлсэн</p> <p>Компанийн дүрэмд энэхүү асуудлыг зохицуулсан бөгөөд ТУЗ-ийн Аудитын хорооны ажиллах журам (ҮЗЭХ)-д дэлгэрэнгүй зохицуулсан. Уг журмын 2.4 дүгээр хэсэгт Хараат бус хөндлөнгийн аудиттай холбоотой асуудлаар тодорхой заасан.</p>	
16	4.2. Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгдөг байна.	<p style="text-align: center;">Биелүүлсэн</p> <p>Хувьцаа эзэмшигчдийн хуралд Аудитын хорооны төлөөлөл оролцож ТУЗ-ийн Аудитын хорооны тайлан, дүгнэлтээ танилцуулдаг. Мөн хөндлөнгийн аудитор хуралд оролцож, нэмэлт мэдээллийг өгөх боломжтой байдаг.</p>	
17	4.3. Дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийн талаарх мэдээллийг компанийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлж тэдгээрт орсон өөрчлөлтийг тухай бүр мэдэгдэнэ.	<p style="text-align: center;">Биелүүлсэн</p> <p>Дотоод аудитын үйл ажиллагааны тайланг тусгайлан гаргаж, компанийн ТУЗ-ийн Аудитын хороонд хүргүүлдэг. Компанийн үйл ажиллагааны тайланд оруулж, олон нийтэд нээлттэй хүргэдэг.</p>	
<p>ТАВДУГААР ЗАРЧИМ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА</p> <p>Төлөөлөн удирдах зөвлөл нь эрсдэлийн удирдлага болон комплайнсын хяналтыг зохистой байдлаар, хараат бусаар зохион байгуулж, тэдгээрийн үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавина</p>			

18	5.1. Компани нь эрсдэлийн удирдлагын заавар болон бүтэцтэй байх ба эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүн, хараат бус байдалд төлөөлөн удирдах зөвлөл хяналт тавина.	<p style="text-align: center;">Биелүүлсэн</p> <p>2023 онд компанийн эрсдэлийн удирдлагын бодлогын баримт бичиг (ҮЗЭХ)-ийг боловсруулан баталж, ТУЗ хяналт тавин ажиллаж байна.</p>	
19	5.2. Төлөөлөн удирдах зөвлөл нь дэргэдээ эрсдэлийн удирдлага хариуцсан хороотой байхыг зорих ба уг хороо нь гурваас доошгүй тооны гишүүнтэй, дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна. Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журам, бүтэц, бүрэлдэхүүнийг компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж, тус хорооны хурлын ирц, хуралдсан асуудал, давтамжийн талаар тогтмол тайлагнана.	<p style="text-align: center;">Биелүүлсэн</p> <p>Компанийн эрсдэлийн удирдлагын бодлогын баримт бичгийг боловсруулан баталж, мөрдөж ажиллаж байна.</p>	
20	5.3. Компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэн нийтэд мэдээлж, тэдгээр эрсдэлийг хэрхэн удирдаж буйгаа тайлбарлана.	<p style="text-align: center;">Хэрэгжүүлэн ажиллаж байна.</p> <p>Компанийн эрсдэлийн үнэлгээг жил бүр хийж ЦХХХЯ-д хүргүүлдэг.</p> <p>Олон улсад мөрдөгддөг сайн засаглалын хүрээнд энэ талаар дурдах, тайлагнах, баримт боловсруулах талаар ТУЗ-ийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэсэн бөгөөд, компанийн хувьд мэдээлэл технологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа тул байгаль шууд хор нөлөөтэй бүтээгдэхүүн, хог хаягдал гарахгүй боловч бидний хэрэглэж байгаа зай, хуучирсан тоног төхөөрөмж зэрэг хаягдлууд байгааг үнэлэн энэ талаарх тайланг удахгүй нийтэд мэдээлэх болно. Мөн нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдсэн ажлуудлыг уг тайланд тусган гаргах юм.</p>	
21	5.4. Компани нь комплайнсын хяналтын заавар болон бүтэцтэй байх ба комплайнсын хяналтын хэрэгжилтийн үр дүн, хараат бус байдалд төлөөлөн удирдах зөвлөл хяналт тавина.	<p style="text-align: center;">Биелүүлсэн</p> <p>2023 онд ТУЗ-өөс компанийн комплайнсын хяналтын бодлогын баримт бичиг (ҮЗЭХ)-ийг боловсруулан баталсан бөгөөд комплайнсын хяналтын хэрэгжилтийн үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавин ажиллаж байна.</p>	

ЗУРГААДУГААР ЗАРЧИМ. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ		
Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байна		
22	6.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг хувьцаа эзэмшигчийн хурлаар ил тод хэлэлцэж батална.	<p>Биелүүлсэн</p> <p>ТУЗ-ийн цалин, урамшуулал, болон бусад зардлын гүйцэтгэлийг жил бүрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд тайлагнаж, тухайн жилийн зардлыг Хувьцаа эзэмшигчдийг хурлаар хэлэлцүүлж батлуулдаг.</p> <p>ХЭХ-ийн тогтоолын хуулбарыг хавсаргав.</p>
23	6.2. Компани цалин, урамшууллын хэмжээг тогтоох үндэслэл болсон ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг цалин, урамшууллын бодлогын баримт бичигт тусгана.	<p>Биелүүлсэн</p> <p>Гүйцэтгэх удирдлагын баталсан бодлогын баримт бичиг болон холбогдох бусад хэм хэмжээнд тусгасан.</p>
24	6.3. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг тусгана.	<p>Биелүүлсэн</p> <p>ТУЗ Гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээнд энэ талаар тусгасан KPI үнэлгээг хавсралтаар оруулсан байдаг.</p> <p>Гэрээний хавсралтыг хүргүүлэв.</p>
ДОЛООДУГААР ЗАРЧИМ. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ		
Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэлнэ		
25	7.1. Компани нь төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичигтэй байна. Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлага нь оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлнэ.	<p>Биелүүлсэн</p> <p>Оролцогч талуудтай хамтран ажиллах бодлогын баримт бичиг (ҮЗЭХ)-ийг батлан гаргаж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p>
26	7.2. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажиллахдаа ямар асуудалд голчлон анхаарч, ямар стратеги баримтлан хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар тусгана.	<p>Биелүүлсэн</p> <p>Жилийн тайланд энэ талаар тусгасан.</p>

27	7.3. Оролцогч талуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, харилцах зорилгоор компанийн цахим хуудсыг үр дүнтэйгээр ажиллуулна.	<p style="text-align: center;">Биелүүлсэн</p> <p>Компанийн Вэбсайтыг олон нийтэд ил тод байлгах, мэдээллийг хялбар байдлаар харах боломжтой шинэчилсэн хувилбарыг ашиглалтад оруулан ажиллаж байна.</p> <p>http://telecommongolia.mn/</p>	
28	7.4. Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх дотоод журам, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дээшлүүлэх дотоод журам, ажлын төлөвлөгөөтэй байна.	<p style="text-align: center;">Биелүүлсэн</p> <p>Компанийн нийгмийн хамгааллын хөтөлбөр (ҮЗЭХ)-ийг ТУЗ-өөс батлан гаргаж, мөрдөгдөх журмыг гүйцэтгэх удирдлагаас боловсруулан гаргаж ажилладаг. Компанийн тухайн жилийн бизнес төлөвлөгөөнд зардал болон ажлын төлөвлөгөөг уялдуулан баталдаг. Сургалтын төлөвлөгөөг үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган, түүнд гаргах зардлыг Бизнес төлөвлөгөөнд тусгасан байдаг.</p> <p>2023 онд мөн Ажилтны санал, хүсэлт, шийдвэрлэх журам (ҮЗЭХ)-ыг ТУЗ-өөс батлан гаргаж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.</p>	
<p>НАЙМДУГААР ЗАРЧИМ. КОМПАНИЙН СОЁЛ</p> <p>Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд компанид бизнесийн ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтнуудад мөрдлөг болгоно</p>			
29	8.1. Компанийн үнэт зүйлс, алсын харааг оновчтой тодорхойлж, хууль ёсны, ёс зүйтэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах зорилгоор төлөөлөн удирдах зөвлөл нь ёс зүйн дүрмийг батлан, нийтэд мэдээлж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	<p style="text-align: center;">Биелүүлсэн</p> <p>Компанийн ТУЗ-өөс үнэт зүйлс, алсын харааг батлан ажилладаг. 2023 онд компанийн үнэт зүйлс, алсын хараа, стратеги зорилтыг шинэчлэн батласан.</p> <p>Мөн Ёс зүйн дүрэм (ҮЗЭХ)-ийг ТУЗ-өөс шинээр баталж, нийтэд мэдээлсэн бөгөөд, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p>	
30	8.2. Аливаа хууль бус үйлдэл болон ёс зүйн зөрчлийг төлөөлөн удирдах зөвлөл, эсвэл түүний дэргэдэх холбогдох хороонд мэдээлэх "шүгэл үлээгчийн" тогтолцоотой байна.	<p style="text-align: center;">Биелүүлсэн</p> <p>Комплайнсын хяналтын бодлогын баримт бичигт тухайлсан заалтыг оруулан баталсан.</p>	

31	8.3. Ёс зүйн дүрмээр авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх болон улс төрийн үйл ажиллагааг дэмжих, /дэмжихгүй байх/ хандив өргөх /өргөхгүй байх/ талаар зохицуулна.	<p>Биелүүлсэн</p> <p>Хүчин төгөлдөр мөрдөж буй Ёс зүйн дүрэмд холбогдох бүхий заалтууд бүрэн туссан байдаг.</p>	
ЕСДҮГЭЭР ЗАРЧИМ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ			
Компани болон төлөөлөн удирдах зөвлөл нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангана			
32	9.1. Компани хөрөнгө оруулагч болон бусад оролцогч талуудад зориулан өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, засаглалын зохион байгуулалт, гүйцэтгэлийн үр дүнгийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа дамжуулан тухай бүр хүргэнэ.	<p>Биелүүлсэн</p> <p>http://telecommongolia.mn/</p>	
33	9.2. Компани хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөртэй байх ба хөрөнгө оруулагчидтай харилцах, мэдээлэл солилцох цахим сувгийг хөгжүүлнэ.	<p>Биелүүлсэн</p> <p>2023 оны ТУЗ-өөс хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөр (ҮЗЭХ)-ийг батлан гаргасан бөгөөд хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p>	
34	9.3. Компани хувьцаа эзэмшигчийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах, санал өгөх, мэдээлэл авах зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх бололцоо, нөхцөлийг бүрдүүлнэ.	<p>Биелүүлсэн</p> <p>Нөхцөлийг бүрэн хангаж ажилладаг.</p> <p>Компанийн вэбсайтад Хувьцаа эзэмшигчдэд зориулсан буланг тогтмол ажиллуулж байна.</p> <p>Холбоос: Хувьцаа эзэмшигчдэд</p>	
35	9.4. Компанийн үйл ажиллагааны чиглэл, өмчлөлийн бүтэцтэй холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдийн санал өгөх эрхээ хэрэгжүүлэхэд нь онцгойлон анхаарна.	<p>Биелүүлсэн</p> <p>Компанийн вэбсайтыг шинэчлэн зохион байгуулж мэдээллийг вэбсайтад бүрэн байршуулсан.</p>	
36	9.5. Компани болон хувьцаа эзэмшигчдийн нийтлэг ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх зорилгоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журамтай байх ба түүний хэрэгжилтийг нийтэд мэдээлнэ.	<p>Биелүүлсэн</p> <p>Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журам (ҮЗЭХ)-ыг батлан гаргаж, хэрэгжилтийн ханган ажиллаж байна. Мөн сонирхлын зөрчилтэй хэлцэл хийсэн эсэх талаар хөндлөнгийн аудитад мэдээлэл өгч ажилладаг.</p>	2024 онд 10 сарын 30-ны өдрийн байдлаар сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгдээгүй.

Санамж:

Компани нь засаглалын зарчмуудыг Монгол Улсын үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад үнэт цаасаа бүртгүүлсэн бүх хуулийн этгээд хэрэгжүүлнэ.

Тухайлбал, "МХБ" ХК-ийн 1-р ангилалд бүртгэлтэй үнэт цаас гаргагч нь кодексийн зүйл тус бүрээр энэхүү маягтын дагуу хэрэгжилт, эсхүл тайлбарыг бүрэн, 2-р ангилалд бүртгэлтэй этгээд 95 хувийг хангасан байна.

Хэрэв дээр дурдсан шалгуурыг хангаагүй буюу хэрэгжүүлээгүй эсвэл тайлбарлаагүй тохиолдолд Тухайн ХК-ийн МХБ-ийн бүртгэлийн ангиллыг бууруулах үндэслэл болох ба нөгөө талаас хөрөнгө оруулагч шийдвэр гаргахад нөлөөлөх шалтгаан болно.

Хавсаргасан материал

1. ТУЗ-ийн гишүүдэд зориулсан 2024 оны жилийн сургалтын хөтөлбөр
2. ТУЗ-ийн дэргэдэх хороодыг шинэчлэн байгуулсан тогтоол